

**Гадаад мужийг засах яам (манжаар *tulergi golo-be dasara jurgan* буюу хятаар *li-fan-yuan*)-Наас 1815 оны ‘гадаад муж’-ид зориулан гаргасан хууль зүйлийн бичиг нь ноёнлон захирах ухаалаг бодлого байв уу?**

**Удо Б. Баркманн**

Тадаад муж” (*манжаар tulergi goto*) буюу Монгол Төвдийн ард түмэнд зориулан гаргасан Манж Чин улсын хууль зүйлийн бичгийн түүхэн эх сурвалжид эзэлдэг онцгой байр суурь, өндөр ач холбогдлыг үл тоомсорлон судалгааны ажил ховорхон хийгдэж байна.

Нэгдсэн нэг эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх, чингэхдээ амьдрах арга, угсаатны соёлоороо өөр өөр хүмүүсийг ерөнхий нэг жишиг болсон журманд оруулах гэсэн оролдлого нь манжийн хааны стратегийн зорилтын нэг үүрэг байв. Энэхүү эрх зүйн хэм хэмжээ нь төвийн гүрний захиран засах хэрэгсэл, хятад төвтэй батлан хамгаалах бодлогын салшгүй нэг хэсэг байсан бөгөөд Чин улсын ашиг сонирхлын хүрээнд Гадаад муж"-ийн нийгмийн болон бусад хөдөлгөөнтэй байдлын эсрэг үйлчлэх үүрэгтэй байв.

Гадаад муж"-ийг засах хууль зүйлийн бичгүүд түүхэн үйл явцын дунд боловсорч бий болжээ. Энэхүү түүхэн үйл явцыг юуны өмнө тоймлон өгүүлье.

Манжийн анхны эзэд хаад харьяандаа саяхан оруулсан монголчуудыг аль хэдийнээс анхааралдаа авч, дээр дурдсан үүргээ биелүүлэхийн төлөө ажиллаж эхэлсэн ажээ. Үүнд манж нарын хууль эрх зүйн ойлголтыг монголчуудынхтай харьцуулахад оюуны илүү өндөр төвшинд арай хүрээгүй байж болзошгүйг харгалзан үзэх хэрэгтэй юм. Манж нарт хятад түшмэд тусалж байсан бөгөөд “Улсыг захирах тухай 1622<sup>1</sup> оны Нурхачийн зарлиг”-т дурдсанчлан манж нар хятадуудын үгийг сонсдог, үнэлдэг байсан учраас манж нарын зарим шийдвэр ямар нэг

<sup>1</sup> M. Weiers, *Nürhacis Verlautbarungen über die Staatsführung aus dem Jahre 1622 und ihre Überlieferung, in Aetas Manjurica*, Tomus 3, Wiesbaden 1992, S. 432-478.

хэмжээгээр хятадын хууль эрхийн нөлөөлөл дор гардаг байсан байж магадгүй юм.

Эрүүгийн хууль, шүүх хурлын анхны журам, дайны эрх зүйг тодорхойлж, бэлчээр нутгийг тогтоож, нутгийн хил давах болон нутаг сэлгэхийг хориглож, зохих шийтгэлийг оноосон 1631 мөн 1632<sup>2</sup> оны Манж-Монголын анхны хуулиудад монголын хууль цаазнаас тусгаж авсан зүйл цөөнгүй бөгөөд ял шийтгэлийн талаархи хуулийн заалтыг чангатгасан байдаг. Чингэхдээ ял шийтгэлийн хэмжээ адил тэгш байсангүй, харин гэмт хэрэгтэн нийгмийн аль ангилалд харьяалагдаж байгаагаас хамаарч ял шийтгэлийн хэмжээг тогтоож өгсөн байв.

Түүхч Нацагдорж “Халхын түүх”<sup>3</sup> номондоо бичсэнчлэн өвөрмонголчууд манжийн эрхшээлд орсноос дөрвөн жилийн хойно буюу 1640 онд Манж гүрэн хүчирхэгжиж байгаагаас сэргэмжилж Халх-Ойрадын ноёд чуулж хууль цаазаа<sup>4</sup> гаргаснаар хоёр талын хууль цаазыг эсрэгцүүлэн судлах ажил эзнээ хүлээх болжээ.

Нэг талаар манжийн дээдэс нар хятаджиж, нөгөө талаар "гадаад муж"-ийг засах хууль зүйлийн бичгийг боловсруулахад хятад түшмэдийн нөлөө нэмэгдсэнээр манж нарын хууль эрх зүйн ойлголт түүхэн богино хугацааны дотор чанарын хувьд өөрчлөгдсөн. Тадаад муж"-ийн ард түмэнд зориулан хууль зүйлийн бичгийг зохиох үүрэг *Мопддо уати* (Монгол яам)-аас өрх тусгаарлан 1638 онд байгуулагдсан *Li-fan-yuan* (Гадаад мужийг засах яам)-д ноогдсон.

Хятад түшмэдүүд бэлтгэж өгсөний хойно Хуандий бээр “Тэнгэрийн таалалдаа соёрхон” (манжаар *abkai hese-i forgon-be aliha*) гаргасан зарлигийг жил бүр *Li-fan-yuan*-аас гаргадаг байв. Хуандигийн зарлигийг заавал дагах ёстой, үл дагах аваас амь нас, эд хөрөнгөнд аюул учирдаг байв.

Иймэрхүү маягаар бэлтгэгдсэн хааны зарлиг улам бүр олширсоор байлаа. Халх Монголыг Долон Нуурт дагаар оруулах ёслол болохын урьдаар халх монголын ноёдод гол гол хууль зүйлийн бичгийг тайлбарлан таниулж өгөхийг *Li-fan-yuan* Өвөр Монголын ноёдоос 1691 онд шаардсан байдаг.

Долон Нуурт ёслол чуулганы ажиллагааг хийснээр Халхад Манж-Хятадын ноёрхол эхэлсэн. Манжийн хаан Халх Монголын хошуу нутагт захирагдах ёс, хараат байдлыг хадгалан үлдээж, дасан зохицсон

<sup>2</sup> M. Weiers, *Mandschu-mongolische Strafgesetze aus dem Jahre 1631 und deren Stellung in der Gesetzgebung der Mongolen*, in *Zentralasiatische Studien* 13(1979), S. 137-190; *Die mandschu-mongolischen Strafgesetze vom 16. November 1632*, in *Zentralasiatische Studien* 19(1986), S. 88-126.

<sup>3</sup> Ш. Нацагдорж, *Халхын түүх*, Улаанбаатар 1963, 34-р хуудас;

<sup>4</sup> *Их цааз "Великое уложение"*, *памятник монгольского феодального права XVII века*, Ойрадский текст, транслитерация свободного ойратского текста, реконструированный монгольский текст и его транслитерация, перевод, введение и комментарии С. Д. Дылыкова, Москва 1981.

амьдралынх нь хэв маягийг хөндөлгүй орхиж, халх монголын ихэс ноёдыг албандаа хүчин зүтгүүлсэн.

Үүний тулд Манжийн хаан хошуу нутагт засаг захиргааны хуваарийг нэвтрүүлсэн. 18-р зууны туршид Манжийн хаан, аймаг хошуудыг байнга жижиглэн хувааж байснаар 1). засаг ноёдын эрх мэдлийг хязгаарлаж 2). засаг захиргааны сүлжээг улам нарийсгаж улмаар тавих хяналтыг сайжруулах гэсэн ажээ. 1691 онд Халхад 34 хошуу байсан нь 1725 онд 74, 1755 онд 82, 1815 онд эцэс ээ 86 болсон. (Энэ дашрамд дурдахад социализмын үед Монгол Улс 299 суманд (1981 оны байдлаар), 1997 онд 342 суманд хуваагдаж, аймгийн тоо дээрхи хугацаанд 18-аас 21 болтлоо өсчээ.)

Долон Нуурын ёслолын ажиллагаа болсноос хэдхэн жилийн дараа буюу 1696 онд Манжийн Энх-Амгалан хаан бээр 1626-1696 оны хооронд монголчуудад зориулж гаргасан хууль цаазын бичгийг анх удаа эмхтгэх ажлыг хийлгүүлсэн.

Арай хожуу буюу 1709-1770 оны хооронд Түшээт Хан, Эрдэнэ Шанзодба нарын оролцоотойгоор хуулиудыг багцалж гаргасан. Үүнд *Li-fan-yuan-ы* түшмэд мөн оролцсон байж таарна. Энэ багц хууль Халх журам<sup>5</sup> гэсэн нэрээрээ алдаршсан бөгөөд *Li-fan-yuan-аас* гаргасан хуулиудын хамтаар Халхын дотоод амьдрал, ялангуяа Жавзандамба хутагтын Их Шавийн хүрээний ба харьцангуй бие даасан сүмийн аж ахуйн үйл ажиллагааг зохицуулж байв. Халх Журмын хуулийн заалтыг манжийн хууль цааз хүчингүй болгох давуу эрхтэй байв, гэвч амьдрал дээр байдал нэлээд өөр байсан.

Зарим хүмүүс өнгөц харахад монгол, манж-хятадын хууль цаазыг нэгэн зэрэг дагах нь зөрчилдөх юм шиг санагдаж болох юм. *Li-fan-yuan-ы* эрх зүйн хэм хэмжээ нь Монголыг Хятад гүрэнд нэгтгэх, Монголоор хятад төвтэй батлах хамгаалах бодлогыг дагаж биелүүлэх ажлыг хангахад чиглэж байсан бол Халх журам нь сүмийн аж ахуйн үйл ажиллагаа болон амьдралын уламжлалт хэв маягийг өөрчлөлгүй үлдээх эрх зүйн орчинг бүрдүүлж байв.

Халхын засаг захиргааны систем улам нарийсч улмаар төвлөрсөн бус байдлаас төвлөрсөн тогтолцоонд шилжихийн хэрээр *Li-fan-yuan-аас* бэлтгэж өгсөн хууль зүйлийн шинжтэй хааны зарлиг тооны хувьд улам нэмэгдэж байсан. Эдгээр зарлиг голдуу Улиастайн Жанжны яаманд ирдэг бөгөөд зөвхөн зарим зарлигийн хуулбар хааяа нэг тохиолдолд хошууны тамгийн газар очдог байв. Манжийн хааны зарлиг нэг талаар төрийн хар хайрцагны бодлого байсан агаад эдгээр зарлигаас алийг нь олон нийтэд тайлбарлан таниулах вэ, хэрэгжүүлэх вэ гэдгийг Жанжин өөрөө шийддэг байсан. Энэ нь манж хааны гаргасан хууль цааз нутгийн бүх хэсэгт хэрэгжидэг болоход бас л хол байсан гэсэн үг. Үнэндээ орон нутагт эзэн хааны шийдвэр гаргах боломжийн хүрээ урьдын адил нэн их байсан бөгөөд Монголд ч тэр Төвдөд ч тэр орон

<sup>5</sup> *Qalq-a Jirum*, Traduit ent russe par Dr. Zamcarano, in *Sudia Mongolica*, Tomus I, Fasc. 1, Ulaanbaatar 1959; *Qalq-a Jirum*, in *Monumenta Historica* Tomus II. Fasc. 1, Ulaanbaatar 1963; *Sili-yin yool*, 1989.

нутгийн язгууртнууд шийдвэр гаргахдаа хууль зүйн дагуу биш харин өөрсдийн бодож байгаагаараа л шийдэх нь амьдрал дээр цөөн бус байв.

Гэвч дор дурдах хэрэг явдлын улмаас төдөлгүй Монгол Төвдөд байдал өөрчлөгдөхөд хүрсэн. Манжийн хаан 1747 онд Төвдийн дэд хаанд өргөмжилсөн Жүрмэднамжил(‘Суиг-тес1 гпат-гдуа1)-ийг 1750 онд хятад амбан Лхасад амь насыг нь хөнөөсөн. Төвдийн энэ дэд хаан бээр баруун монголчуудтай холбоо сүлбээ тогтоохыг эрмэлзэж байсныг илрүүлсэн ажээ. Түүнийг ийнхүү хөнөөсөн явдал Лхас болон тэр орчмын ардуудын уур хилэнг бадрааж, Лхас орчимд амьдарч байсан бүх хятадуудыг хөнөөсөн. Манж хаан цэргээ тийш нь илгээж, 1750 он гэхэд тэнд дүрэм журмыг дахин сахиулсан.

Чухам бараг энэ үед буюу 1756-1758 оны хооронд Халхтай хил залгаа Ойрад Монголд Амарсанаа, Чингүнжав нарын удирдсан бослого хөдөлгөөн дэгдэхэд Манжийн хаан цэргээ илгээж бослогыг даржээ.

Манжийн хаан энэ байдалд дүгнэлт хийгээд Монгол, Төвдийг интеграцчилах арга хэмжээг авсан. Лхаст суусан хятад амбан хятад төвд цэргээс бүрдсэн Төвд дэх цэргийг командалж, том мяндагтай лам нарыг тодруулах болон гол түшмэдийг сонгох явцыг хянаж, Төвдийн гадаад харилцаа холбоог шалгаж байх болжээ. Тэдгээр амбаныг төвдийн дотоод бүхий л асуудалд хөндлөнгөөс ил цагаанаар оролцохгүй байхыг Бээжин шаардаж байсан ч тэд шийдвэр гаргах бүхий л чухал асуудалд оролцож байхыг тэмүүлж байв.

Ойрад Монголд бослого тэмцэл гарсанд хариу арга хэмжээ болгож *Li-fan-yuan* Халх Монголын засаг захиргааны тогтолцоог төвлөрсөн системд оруулсан. Харилцан бие биеэ хянах зарчмын үндсэн дээр ажиллах хоёр амбаны нэг буюу монгол амбан 1788 онд, манж амбан 1761 онд тус тус Их Хүрээнд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. 1762 онд стратегийн чухал нутаг болох Ховдод мөн нэг амбаныг нэмж суулгасан.

Бээжингийн *Li-fan-yuan* харин "гадаад муж"-ийг интеграцчилах тухай л бодолхийлж байжээ. Хятад түшмэд үүнийг зөвхөн хатуу чанд хууль журмын хүчээр гүйцэлдүүлж чадна гэж үзэж байв. Монголчуудын хууль эрхийн асуудлыг зохицуулж байсан хааны зарлиг тоогоор дэндүү олон, утга агуулгын хувьд бүрхэг байсан. Хааны урьдын зарлигийн утга агуулгын зөрчилтэй байдлыг арилгаж, хууль эрхийн бичиг бүрийг нягтлан хянаж тухайн үед хэрэглэгдэж байсан хууль зүйлийн бичгийг эмхэтгэх шаардлагатай болсон.

*Li-fan-yuan*-аас 1789 онд *mongdo fafun-i bithe* буюу “Монголын хууль зүйлийн бичиг”-ийг манж, монгол хэлээр хэвлэн гаргасан. Тадаад дотоод хошуу” (манжаар *dorgi tulergi gūsa*) өөрөөр хэлбэл бүх монголчууд дагаж мөрдөх энэхүү “Монголын хууль зүйлийн бичиг” нь 12 дэвтэр буюу нийт 209 зүйлээс бүрдэх бөгөөд ихэс язгууртан, түшмэд албан хаагчдын зэрэг дэв, төсөв мөнгөний асуудал, алба гувчуур залгуулах, аймгийн чуулганыг (*cr/ulyan*) зарлан хуралдуулах, цэрэг дайчлах, хилийн харуул,

эрүүгийн хууль, шүүх хурлын журам зэргийг зохицуулж байв.<sup>6</sup> "Лам нарын хэргийн хууль"-ийн тухай 11-р дэвтрийг "хууль" (манжаар *kooli*) хэмээн тодорхойяа нэрийдсэний учир бусад дэвтрээсээ ялгагдаж, онцлон тэмдэглүүштэй байлаа. Гэтэл бусад дэвтрийг зөвхөн сэдвийнх нь толгой үгээр гарчигласан байна. *Мопддо fafun-i bithe* нь 1696 онд Энх-Амгалан хааны гаргасан эмхтгэлд орсон хааны хуучин зарим зарлиг мөн түүнчлэн цоо шинэ зүйл ангиудыг өөртөө багтааснаараа холимог шинжтэй сурвалж бичиг байлаа. Эдгээр цоо шинэ зүйл ангиуд нь эрүүгийн үйлдлийг тодорхойлох, шийдэх арга замыг тогтоох гэсэн хуулийн заалтын энгийн загвараар томъёологдсон ажээ.

Бээжин монголчуудын уламжлалт нүүдлийн амьдралын хэв маягийг үлдээх явдалд эргэлзээгүй боловч нүүдэлчид хоорондоо бэлчээрээ булаацалдаж тэмцэлдэх, хэсэг бүлгээрээ эвсэх зэрэг элдэв хямрал зөрчил, аюул заналыг урьдаас зайлуулахын тулд нүүдэлчдийн хөдөлгөөнтэй байдлыг багасгах, хязгаарлах тун их сонирхолтой байжээ. *Мопддо fafun-i bithe-ийн* тавьж байсан гол шаардлага нь нүүдэлчдийг тодорхой нэг нутагт нь барьж байх явдал юм. Энэ хууль бичиг нь хошуу нутгийн хил хязгаарыг давах, хошуу нутгаас гарч нутаглахыг хориглож байлаа. Дээр дурдсан сүүлчийн заалтыг зөрчсөн тохиолдолд хошуу ноёны бүтэн нэг жилийн пүнлүүг олгохгүй, хошууны ардын хувьд "бүх мал хөрөнгө, гэр бараа"-г (*boigon ulha-be yooni*) хураана хэмээн заасан байв.<sup>7</sup> Энэ нь энгийн үгээр хэлбэл эдийн засгийн сүйрэлд орно гэсэн үг юм.

Нүүдэлчдийг хуулиар хатуу зааж өгсөн газарт тогтоон барьснаар "Монголын хууль зүйлийн бичиг"-ийг амьдрал дээр биелүүлж, түүний хэм хэмжээг хэрэгжүүлэх илүү таатай нөхцөлийг бүрдүүлж байлаа. Европын ухагдахуунаар (нэн болгоомжлон) адилтган өгүүлбэл *Li-fan-yuan* нь *мопддо fafun-i bithe-ээрээ* монголчуудын хувьд анхны *corpus iuris civilis-э* бий болгосон төдийгүй "Лам нарын хууль"-иараа улсын зүгээс сүм хийдийн харилцааг зохицуулах тусгай хууль журмыг анх удаа гаргажээ.

Хошуу ноёд Улиастайн жанжин эсвэл Их Хүрээ, Ховдын амбаны тушаалгүйгээр өөрийн хошуу нутгаа орхин явж болдоггүй байснаас үзэхэд зөвхөн шарын шашин л бүх монголчуудыг холбож нэгтгэсээр байжээ. Сүм хийдүүдийн хоорондын харилцаа улам өргөжиж бүх аймгуудыг хамрах болсон, том лам нар харьцангуй бие даасан

<sup>6</sup> monggo fafun-i bithe, monggo fafun-i bithei uheri äosohon, ujui debtelin: hafan jergi, orin duin hacin; jai debtelin: boigon taküran, orin ilan hacin; ilaci debtelin: hengkilenjire jafanjire, uyun hacin; duici debtelin: culgan isara, coohara, juwan ilan hacin; sunjaci debtelin: jecen, karun. juwan nadan hacin; ningguci debtelin; hülha, holo. gücin sunja hacin; nadaci debtelin: niyalma-i ergen, juwan hacin; jaküci debtelin: kabsara gercilere, sunja hacin; uyuci debtelin: jafara, ukandara, orin hacin; juwanci debtelin: buyarame weile, juwan jaküci hacin; juwan emuci debtelin: lamasai kooli, ninggun hacin; juwan juweci debtelin: weile beidere, orin uyun hacin.

<sup>7</sup> "Хуваасан газрын захаар өнгөрсөн тасарч өөр нутгаар явах нь нэгэн зүйл: хуваасан газрын захыг өнгөрсөн тасарч өөр нутгаар явбаас хошуу захирсан захирагч ван, бэйл, бэйс, гүн, тайж, тавнан нар болбоос нэгэн жилийн пүнлүү огтол. Пүнлүүгүй тайж тавнан нар болбоос тавиад морин ав. Энгийн хүн болбоос хуучин мэдсэн хүн түүний биеийн хамт өрх малыг бүрэн автүгай. " 557, 683 (5/2 dendehe ba-i hen>en-be duleme lakcafi encu nukteme jaburengge; emu hacin: dendehe bai hen>en-be duleme lakcafi encu nukteme yabuci, gbisa-be kadalaha kadalaha wang beile beise gung taiji tabunang se oci, ernte aniyai funglu faita. funglu акы taiji tabunang se oci, susaita morin gaisu. bai niyalma oci, fe saha niyalma terei beyebe suwaliyame boigon ulha-be yooni gaikini.)

байдалтай болсон, Ар Монголын Жавзандамба зэрэг том том лам нарын хүрээ хийдэд төвлөрсөн байдал нэмэгдэж ирсэн зэрэг нь, шарын шашныг манжийн хаан гартаа эрх мэдлийг төвлөрүүлэх бодлогодоо ашиглах хэжээнд хүргэжээ. Манжийн хаан дээр үеэсээ монголчуудад; хандахдаа эн тэргүүнд шарын шашинг хүндэтгэн үздэг байлаа. /

Үүнд мөн өөр нэгэн шалтгаан байсан. 1689 онд Хаант Орос Улс Нерчинскийн гэрээг байгуулснаас хойш Хятадыг хэлэлцээрийн ширээнд суухыг байн байн шахах болсон. Халхчуудын нэгэн адил шарын шашинтай буриадууд Хаант Оросод нутаглаж байсан бөгөөд Хаант Орос буриадууыг Халхад улс төрийн зорилгоор нэн сайн ашиглаж байв.

Шарын шашныг хязгаарлах ёстой тэгэхдээ Конфуцийн номлол дахь арга билгийн ухаанаар энэ шашныг дэмжиж байгаа гэсэн сэтгэгдлийг төрүүлэх ёстойг Манжийн Эзэн хаан маш сайн ойлгож байсан.

Төвд дэх Gurkha-н дайралт нь сайхан шалтаг болсон. Хятад генерал Fu Kang-аг төвдийн ихэс язгууртан, санваартан лам нарыг Gurkha-н зөрчилдөөнд "буруутай." хэмээн цаазлахаас 'арай. өмнөхөн түүний удирдлаган дор Тэнгэрийн тэтгэсэн хааны зарлигийг бэлтгэн гаргасан бөгөөд энэ зарлигийг Тэнгэрийн тэтгэсэн хаан бээр 1793 онд гаргасан.<sup>8</sup>

Энэхүү хааны зарлигийн дагуу хятадууд Төвдийн шашны болон шашны бус хүрээнд брловсон хүчний бодлого, засаг төрийнх нь бүхий л чухал хэрэгт тавих хяналт шалгалтаа чангатгасан, Бүх том лам нарыг (Далай лам болон Банчин эрдэнэ нарыг оруулаад) шавга (sibay-a) татах аргаар тодруулахдаа амбаны шалгалтан доор явуулахыг 1-р зүйлд заасан байдаг. Лхаст суух амбад нь хууль цаазад бичсэнчлэн Далай лам болон Банчин эрдэнэ нартай ижил зиндааны байр суурийг эзлэх бөгөөд бүх там лам нар, гол түшмэд нар мөн Дашлхүмбийн хамба лам амбанд ажлаа тайлагнах үүрэгтэй хэмээн 10-р зүйлд заасан. 12-р зүйлд Далай лам, Банчин эрдэнэ нарын ураг садангийн Хүн төр барих аливаа хэрэгт оролцохыг хоригложээ. Амбан нар Төвдийн гадаад харилцааны бүхий л хэлбэрийг шууд газар дээр нь гардан хэрэгжүүлж, Далай лам болон бусад мяндагтан лам нарын захидал харилцааг амбан нар ямар нэгэн хаалт саадгүйгээр шууд шалгаж байжээ (14, 23-р зүйл). Төвдөд очих хүсэлтэй байгаа бусад улсын харьяат нар энэ тухайгаа мэдэгдэж нэвтрэн орох зөвшөөрөл авах ёстой (29-р зүйл) бөгөөд сүм, хийдийн хамба нарыг томилох асуудлыг хятад амбан шууд шалган хянаж байв (18-р зүйл). Цэрэг хуралдуулах, зоос үйлдвэрлэх, түшмэд томилох болон алба татварын бодлого, эрүүгийн хууль журмыг хааны зарлигийн дагуу шийдэж байжээ. Эдгээр арга хэмжээний эцсийн үр дүнд Бутан, Балбё,

Г :<sup>8</sup> Хятад текст болон төвд, эхээс зургийн аппаратаар татаж буулгасан сайн уншигдахуйц текстын зэрэгцээ англи орчуулгыг төвдийн түүхийн архивыг цуглуулгаас олж үзэж болно. A Collection Historical Archives of Tibet, Lhasa, 1995, Doc.50, Үүнээс тэс өөр бас нйгэяангли орчуулгыг Ya Han?hang-aae үзнэ үү. Va Hanziiangi the. & iQgrgphies of the Dalai Lhamas; Beijing 1991, S.72-83, . . . ■

Монгол Улсын Төв Номын-санд хадгалагдаж байгаа Тэнгэрийн тэтгэсний онд шинэ тогтоосон хуудас хуулийн дэвтрээс Ш. Нацагдорж ишлэл авсан Оолно. Ш. Нацагдорж, Халхын түүх, Улаанбаатар 1963,9-р хуудас; ...

*Sikkim* ('bras-ljongs) зэрэг улсуудын нөлөөнөөс Төвдийг тусгаарласан юм.

Манжийн хаан 29-н зүйл бүхий зарлиг гаргаж, ганцхан Төвдийг л онцлон анхаарсан хэрэг бус бөгөөд мөн тухайн жил Гадаад Монголд том лам нарыг тодруулах явдлыг журамласан зарлиг гарсныг харгалзан үзвэл тодорхой болох юм. Уг зарлигт бүх том хутагт хувилгаадыг *Li-fan-yuan-p*, бүртгүүлэх бөгөөд зөвхөн бүртгэлтэй хутагт хувилгаадыг Монголд суугаа амбаны хяналт шалгалтан дор хойд дүрийг нь тодруулж байхаар заажээ. Мөн уг тогтоолд цаашид Жавзандамба хутагтыг зөвхөн Төвдөөс тодруулна гэж хуульчилж өгсөн.<sup>9</sup>

Энэ хоёр зарлигийг биелүүлснээр шарын шашны тэргүүлэгч лам нар бие даасан боловсон хүчний бодлого болон Манжийн хаанаас хараат бус шашны бодлого явуулах ямар ч боломжгүй болсон.

Тадаад муж"-ийн ард түмэнд бүгдэд үйлчлэх хууль журмыг боловсруулах ажлыг *Li-fan-yuan* хийж эхэлжээ. Хуулиудаа дахин хянаж эмхлэх үүргийг түшмэдүүд хүлээсэн. 1811 онд *Li-fan-yuan-ы* үүрэг гүйцэтгэгч сайд Хуандийд ажлынхаа явцын талаар мэдээлсэн байдаг. Чингэхдээ *монддо fafun-i bithe-r* бараг хориод жилийн өмнө анх гаргасан бөгөөд одоо нөхцөл байдал өөрчлөгдсөн тул хуулийг дахин боловсруулах шаардлагатай байгаа тухай тэрээр дурдсан байдаг.<sup>10</sup> Хуулийг дахин боловсруулах комиссыг байгуулж ажиллуулсан байна. 1815 онд уг комисс "Зарлигаар тогтоосон гадаад мужийг засах яамны хууль зүйлийн бичиг" (*манжаар hese-i toktobuha tulergi golo-be dasara jurgan-i kooli hacin-a bithe*)<sup>11</sup> хэмээх Хуулийн эмхтгэлийг бэлэн болгосноо мэдэгдсэн. Анхны *монддо fafun-i bithe-ээс* 20 зүйлийг орхиж, үлдсэн 189 зүйлийг 178 болгож бүгдийг бүрэн дүүрэн засварласан. 1815 онд анх хэвлэгдсэн 63 дэвтэр хууль зүйлийн бичгийг анх манж, монгол хожим хятад хэлээр модон бараар хэвлэж гаргасан. Модон бараар хэвлүүлсэн гэдгээс үзэхэд олон тоогоор хэвлэж түгээсэн болов уу гэж хэлж болохоор байна.

*Монддо fafun-i bithe-мэй* харьцуулахад текстүг дахин хянаж боловсруулснаар түүний хэлбэр нь өөрчлөгдсөн байна. Хуулийн заалтууд утгын хувьд бодит байдалд ойр, элдэв чимэггүй маш тодорхой бичигдсэн бөгөөд мэргэжлийн хүмүүс үүнийг тайлбарлах шаардлагатай байв. Энэ эмхтгэлд эзэн хааны хуучин зарлигуудаас огт ороогүй. Эдгээр хуулийн заалт нь өмнө дурдсан тэр л зарчмын дагуу өөрөөр хэлбэл *эрүүгийн үйлдлийг тодорхойлох, шийдвэрлэх* гэсэн бүтэцтэй байв. Хятадын хууль цаазын эрдэмтэд үүнийг судалж байгаа нь лавтай, гэхдээ монгол, манж, хятадын хууль эрх уг хуулийн эмхэтгэлд хэрхэн нөлөөлснийг нарийн судлах ажил үгүйлэгдсээр байна. 1815 оны Хуулийн эмхэтгэл нь сүм хийдэд голчлон мөрдөж байсан Халх Журмыг ямар нэгэн хэмжээгээр хүчингүй болгосон эсэхийг шүүх хурлын баримт бичгүүдийн

<sup>10</sup> cf. da kooli-i bithe-be banjibure jalin da wesimbuhengge, tulergi golo-be dasara jurgan-i gingguleme wesimburengge, Модон бар, зохиогчийн хувийн цуглуулгаас.

<sup>11</sup> Үүнд орос орчуулга байдаг боловч тодорхой бус байдгийн улмаас (магадгүй хятад текстээс орчуулсан болов уу) тэр болгон түгээмэл ашиглагддаггүй: С., Уложение китайской палаты внешних сношений, С. Петербург. 1828.

тусламжтайгаар дор хаяж судлан үзэх шаардлагатэй байна. Хуулийн эмхэтгэл нь модон бараар хэвлэгдэж олон газар түгсэн тул хааны зарлиг урьдынх шиг нууцлагдмал байхаа больсон бөгөөд энэхүү Хуулийн эмхэтгэл монголын хууль эрхийг хэр зэрэг энгийн ойлгомжтой, дагаж мөрдөж болохуйц, зарга шүүлгэж болохоор болгосон бэ гэдэг асуудал гарч ирнэ.Түүхч Ш.Нацагдоржийн эмхэтгэсэн “Ардын заргын бичиг”<sup>12</sup> нь 19-р зууны эхний хагаст эгэл ардаас ноёдын эсрэг гомдол зарга гаргах нь эрс өссөнийг харуулж байна.

Хуулийн эмхэтгэл дөрвөн хэсэгт хуваагддаг:

1-р хэсэг нь 55 дэвтрээс бүрдэх бөгөөд Монголчуудын хэрэг явдлыг зохицуулна. “Засаг хошуу” (манжаар *jasak, gūsa*) гэсэн 1-р дэвтэрт түүний үйлчлэх хүрээг тодорхой зааж өгчээ. Энэ нь Монголчуудын 199 хошуу, Түмэд-Монголын хоёр гар болон бусад тусгай газруудад хамаарах юм.<sup>13</sup>

2-р хэсэг буюу “Лам нарын хэргийн хууль ” (манжаар *lamasai kooli*) нь мөн *топдоо fafun-i bithe-p* маш тодорхой дурдсаны нэгэн адил тусгай нэг “хууль” (коон)-ийн талаар өгүүлснээрээ хуулийн бусад хэсгээсээ ялгардаг.

3-р хэсэг буюу Төвдийн хэсэгт “Баруун Зуугийн бүгд хууль”<sup>14</sup> (манжаар *wargi zang-ni uheri kooli*) гэсэн гарчиг бүхий 61, 62-р дэвтэрт төвдийн тухай өгүүлсэн байх бөгөөд энэхүү Хуулийн эмхэтгэл гарах хүртэл Төвд ба шарын шашны хэргийг *Li-fan-yuan-ы* “Харьяат аймгийг даасан ариутгах хэлтэс” (манжаар *harangga aiman-be aliha bolgobure fiyenten, монголоор qariyatu ayimay-i dayaysan ariudqaqu keltés*) хамтатган хамаардаг байжээ. 1793 онд гаргасан 29-н зүйл бүхий хааны зарлиг дээр дурдсан 2 дэвтэрт утгын хувьд тусгагдсан боловч “нэмж зохиосон нь” (манжаар *nonggime banjibuhangge*) гэж тодорхойлсноос үүдэн бүх заалтуудыг шинэ хувилбар хэмээн ойлгох ёстой юм.

4-р хэсэг нь “Оросын хэргийн хууль”(манжаар *oros-i baitai kooli*)-ийн тухай болно.<sup>15</sup>

<sup>12</sup> Ш. Нацагдорж, *Ардын заргын бичиг*, in Monumenta Historica, Tomus IV, Fase. 1, Улаанбаатар 1968.

<sup>13</sup> cf. hese-i toktobuha tulergi golo-be dasara jurgan-i kooli hacin-i bithe, uju-i debtelin, *jasak gbisa*.

<sup>14</sup> Хауер (Hauer) толь бичигтээ төвдөөр “wargi zang “ гэж орчуулжээ. Манжаас хятад уруу “Xizang” (= Tibet) гэж орчуулагдсан байхад (cf. Xiu-man-han-da-ei-dian, Iche manzhu nikan gisun kamchibuha buleku bithe, Xinjiang 1994), харин *Li-fan-yuan-аас* бэлтгэн хянаж гаргасан монгол орчуулганд баруун зуу “baraDun joo” гэж бичсэнээс үзэхэд Төвдийн газар нутгийн хэмжээ бидний бодож байснаас жижигсэх болж байна(сТ Lessing, 1081, popular name for Lhasa).

<sup>15</sup> cf. U. B. Barkmann, Die Manju-Gesetzgebung für die Außenprovinzen aus dem Jahre 1815 zu den russisch-mongolischen Beziehungen, in Aetas Manjurica VI, Wiesbaden 1998, S. 7-11.

“Лам нарын хэргийн хууль” нь монгол төвдийн хууль тогтоомжийг холбох гүүр болж байгаа нь тодорхой юм. Зургаан зүйл бүхий *толддо fafun-i bithe-mэй* харьцуулахад “Лам нарын хууль” нь 56-60 дэвтэр буюу 205 зүйл бүхий таван дэвтэрт багтсан байна.

“Лам нарын хэргийн хууль” нь нэлээд улс төржсөн хууль бөгөөд шарын шашны байгууллагууд болон лам нарынх нь үйл ажиллагааг төрийн сонирхолд нийцүүлэн нэг бүрчлэн зохицуулж байхын тулд төр өөрөө шашны хууль эрхийг бий болгох гэсний илрэл нь “Лам нарын хууль” байлаа.

Манжийн хаан энэхүү хуулиараа Халх Монголын шашны хэрэгт нөлөөгөө бататгах арга замыг хэрхэн хайж байв гэдэг асуудал дээр бид анхаарлаа хандуулж байна. Хууль цаазын бичиг бүр Төвдийн дотоод хэрэгт үзүүлсэн нөлөөллийг шинжлэх ухааны төрөл бүрийн салбарын эрдэмтэд хамтран судлах хэрэгтэй ч энэ өгүүлэлдээ эндээс эхлээд Төвдийн тухай ярихаа азная.

Эзэн Хаант улсын нөлөөллийг бататгах гол урьдач нөхцөлүүдийг өмнө дурдсанчилан 1793 онд бий болгосон бөгөөд Ар Монголын хамгийн том лам Жавзандамбыг зөвхөн Төвдөөс тодруулна гэжээ. Ингэснээр халх монголын ноёд лам нар Жавзандамбыг тодруулахдаа өөрсдийн нөлөөг үзүүлэх боломжгүй болсон. Өндөр гэгээн Занабазараас эхлээд Жавзандамба хутагт бол зөвхөн шашны хүн байгаагүй гэдгийг хэлэхгүй өнгөрч болохгүй юм. Занабазар бол Түшээт ханы хүү, Чингисийн алтан ураг төдийгүй шашны хүндэтгэл, Чингис Хааныг шүтэх үзэл, Чингисийн алтан ураг төрийн алтан жолоог атгах тавилан энэ бүгдийг хослуулсан онцгой этгээд байсан нь тэр үед Монголыг ноёрхож байсан бөгөөд угтаа манж боловч бүрэн хятаджсан Чин улсын хувьд аюултай зүйл байсан. Зөвхөн Төвд хүнийг Жавзандамбад тодруулдаг болгож өөрчилсөн ч манжийн хаанд Жавзандамба хутагт Чингис хааны удмын цусан төрлийн холбоогүй байх нь чухал санагдаж байсан.

Жавзандамба хутагтыг Төвдөд тодруулах ажил хэзээ ч тохиолдлын чанартай байгаагүй. Төвдөд улс төрийн эрх мэдлийг хуваарилах, шавга татах аргаар хувилгаадыг тодруулах, зарим тодорхой хүмүүс, нийгмийн хэсэг бүлгийг нэр дэвшигчдийн жагсаалтнаас хасах зэрэгт Бээжин өөрийн нөлөөг бататгаж байсан.

#### 1. Улс төрийн эрх мэдлийг хуваарилах

“Баруун Зуугийн бүгд хууль”-д “Нэмж зохиосон нь” нэг, хоёрдугаар зүйлд: “Баруун Зууд хоёр сайд суулгаж өмнөд умард Зангийн хамаг хэргийг шийтгүүл. Цөм тусгайлан зарлигаар сайд гаргаж илгээж халуулагтун.”<sup>16</sup> мөн цааш нь “Занд суусан сайд бүх Зангийн хэрэг зүйлийг нэгтгэн шийтгэ. Далай лам Банчин эрдэнэ лүгэ сацлуулан яв.”<sup>17</sup>

<sup>16</sup> hese-i toktobuha tulergi golo-be dasara jurgan-i kooli hacin-i bithe, ninju emuci debtelin, wargi zang-ni uheri kooli, wargi zang-de amban teburengge.

<sup>17</sup> hese-i toktobuha tulergi golo-be dasara jurgan-i kooli hacin-i bithe, ninju emuci debtelin, wargi zang-ni uheri kooli, wargi zang-ni eiten ba-i baita hacin-be gemu zang-de tehe amban-de kadalabume icihyaburengge.

Далай лам, Банчин эрдэнэ нартай эн чацуу хүндлэгдэнэ, мөн амбан нар "хамаг хэрэг" (манжаар *eiten baita*)-ууг шийтгэнэ гэж тодорхой зааж өгсөн нь тэд сүм хийдийн боловсон хүчний бодлоготой холбогдох асуудалд тэгш эрхтэйгээр хамтран шийдэх эрхтэйг харуулж байна.

Уг хуулинд Далай лам, Банчин эрдэнэ нарын садан төрлийн хүн шашны болон шашны бус чухал албан тушаал хашиж болохгүйг зааж өгсөн байдаг. Хуулинд заахдаа "Их бага Тангуд дарга нар жич өмнөд умард Зангийн хэрэг хамаарах лам нарын оронд цөм Далай лам, Банчин эрдэнэ нарын төрлийн ардыг авч хэтэрхий хэрэг захиргавал болохгүй."<sup>18</sup> гэжээ.

## 2. Шавга татах арга

"Лам нарын хэргийн хууль"-нд "Хувилгааныг заах тогтоосон хууль" (манжаар *hübilgan-be jorire toktobuha kooli*) багтах бөгөөд үүнд: "Баруун Зуугийн харьяат захирах олон газар, жич Силингийн харьяат захирах Хөх нуур, Фанзегийн зэрэг газрын дэлгэрсэн хувилгаан цөм Занд сууж хэрэг шийтгэгч сайдад бичиг явуулж, Далай лам луга нэгэн-э нийлж нэрийн шавга бичээд, Их Зууд тахиглах алтан бумба хувинд оруулж бүгдээр хамт нэгэн-э татаж тогтоо."<sup>19</sup>

## 3. Хувилгааныг тодруулах

"Лам нарын хэргийн хууль"-нд (55-р дэвтэр) бичихдээ: "Монгол Фанзегийн аймгаас хутагт ихээхэн ламын хувилгаан дэлгэрэв хэмээн өргөн мэдүүлвээс сул тайж эс бөгөөс албат ард (манжаар *albatu urse*) жич Тангудын харц хүмүүний хөвгүүдийн дотроос заалгуул. Далай лам, Банчин Эрдэнийн төрөл ураг, жич олон монгол хан, ван, бэйл, бэйс, гүн, засаг тайж нарын хөвгүүд ач нарын дотроос хувилгаан заахуйг нийтээр цаазлагтун"<sup>20</sup> гэжээ.

"Гадаад муж"-ийг засах хууль тогтоомжиндоо *Li-fan-yuan* нь Жавзандамбыг Далай лам, Банчин Эрдэнэ нартай эн чацуу гэж заасан. Жавзандамбыг Бээжингийн хааны ордонд <sup>21</sup> бараалхахад түүнийг Далай лам, Банчин Эрдэнэ нараас дутуугүй тансаг сайхнаар хүлээн авах ёслолын үйл ажиллагааны тухай дэлгэрэнгүй бичсэнийг дурдалгүй орхиж болохгүй. Чингисийн удмын ихэс ноёд болох Түшээт хан, Сэцэн ханы зэрэгцээ онцгойлон Жавзандамбаар манжийн хаанд есөн цагааны алба (манжаар *ууил §aniyan-i albabun*) хүргүүлдэг байсныг түүний биед

<sup>18</sup> hese-i toktobuha tulergi golo-be dasara jurgan-i kooli hacin-i bithe, ninju emuci debtelin, wargi zang-ni uheri kooli, dalai lama, bancen erdeni-i mügun-i urse, dabali baita kadalaci ojarahungge.

<sup>19</sup> hese-i toktobuha tulergi golo-be dasara jurgan-i kooli hacin-i bithe, susai jakuci debtelin, lamasai kooli, hübilgan-be jorire toktobuha kooli.

<sup>211</sup> hese-i toktobuha tulergi golo-be dasara jurgan-i kooli hacin-i bithe, susai jakuci debtelin, lamasai kooli, hübilgan-be jorire toktobuha kooli.

<sup>21</sup> hese-i toktobuha tulergi golo-be dasara jurgan-i kooli hacin-i bithe, susai jakuci debtelin, lamasai kooli, jebzundamba hutuktu gemun hecen-de jihede suwayan bosoi wajire cafi indeburengge.

дамжин ирсэн Чингисийн сүр сүнсийг хүндэтгэсэн хэрэг гэж үзэж байна.<sup>22</sup> Эзэн хааны явуулж байгаа шашны бодлого нь сайтар бодож боловсруулагдсан бөгөөд *Divide et impera-гийн* сонгодог зарчмаар асуудлыг шийддэг байжээ. Төвдийн шашны тэргүүнүүдтэй харьцуулахад Жавзандамбын үнэ цэнийг Бээжин нэмэгдүүлэхийг чармайж байсан бөгөөд Жавзандамба хутагтын гүйцэтгэж байсан онцгой үүргийг халх монголын шашныг төвдөөс тусгаар байлгах далд санаатай байжээ гэж ойлгох нь зүйтэй болов уу.

“Лам нарын хэргийн хууль”-нд заасны дагуу монголын хувилгаадыг шавга татах аргаар Бээжингийн хааны ордонд тодруулах үүргийг *Li-fan-yuan-ы* түшмэд хүлээдэг байсныг бид эргэцүүлэн бодоход энэхүү хууль нь төвдөд байсан шарын шашны төвүүдээс монголчуудын уламжлалт холбоо харилцааг таслах зорилготой байсан нь илт байна. 1815 оны Хуулийн эмхэтгэлд монгол нүүдэлчдийг зөвхөн тодорхой нутагт хашиж, хэрвээ зөрчсөн тохиолдолд шийтгэхээр заажээ. Лам нар орон хийдээ орхиж өөр газар зорчихын тулд зөвшөөрлийн бичиг авах шаардлагатай гэжээ<sup>23</sup>. Үүнийг тодорхой хэлбэл хүн ардынх нь чөлөөтэй нүүж хөдлөхийг хязгаарлахын хажуугаар тэд хоорондоо санал бодлоо солилцох явдлыг хааж өгсөн байна. Тадаад муж"-ийг захирахдаа зөвхөн онцгой тохиолдолд л цэрэг зэвсгийн хүчийг ашиглахаар заасан, үнэхээр ухаалаг ноёнлон захирах бодлого гэлтэй!

1815 оны Хуулийн эмхэтгэл монголчуудад 1911 он хүртэл хүчин төгөлдөр байсан бөгөөд үүнийг Богд Хаант улсын төр Жавзандамбатай холбогдсон зарим хэдхэн зүйлийг хасаад хүчин төгөлдөр эрх зүйн хэм хэмжээ хэмээн 1919 он хүртэл баримталж байсан. Энэ нь он удаан жилийн туршид харийн хууль цааз монголчуудын амьдралыг зохицуулж байжээ гэсэн үг юм. Монголчууд төдөлгүй европын эрх зүйн хэм хэмжээ тодруулбал континенталь - европын эрх зүйг чиглэлээ болгож эхэлсэн учраас юуг ч өөрчлөх хэрэггүй болсон.

1989 онд 10-р Банчин эрдэнэ нас барсны дараагаар Чин улсын үеийн уламжлалыг Бээжин дагаж, өөрөөр хэлбэл 1815 оны Хуулийн эмхэтгэлд заасны дагуу Банчин эрдэнийн шинэ дүрийг тодруулах ажлыг Бээжин хариуцах ёстой гэсэн шаардлагыг тавьсан. Бээжин дэх Нийгэм судлалын академийн эрдэмтэд 1995 онд гаргасан нэгэн өгүүлэлдээ ийнхүү бичжээ. “Алтан бумбан дотроос нэрийг сугалж гаргадаг тэр систем нь төвдийн хэрэг явдлыг зохицуулах эмх цэгцтэй дүрэм журмын хамгийн ач холбогдолтой хэсэг юм. Энэ нь улс төр, эрх зүйн процедурт ч нийцэхээр барахгүй мөн шашны дэг жаягт ч тохирно. Хятадын төвийн засгийн газрын авторитет мөн уг засгийн газар Төвдөд засгийн эрхийг байнга хэргэжүүлж байгаа түүхэн бодит байдал энэ системд тусгалаа

<sup>22</sup> hese-i toktobuha tulergi golo-be dasara jurgan-i kooli hacin-i bithe, juwan nadaci debtelin, albabun jafanjirangge, kalka-i jafanjire uyun saniyan-i albabun-i kooli.

<sup>23</sup> hese-i toktobuha tulergi golo-be dasara jurgan-i kooli hacin-i bithe, gūsin duici debtelin, jecen-de fafularangge.

олжээ. Энэ нь монгол төвдөд нийгмийн тогтвортой байдлыг хамгаалж хадгалахад үйлчилсэн байна...”<sup>24</sup>

Энэтхэгт тодорч өндөр насыг зооглосон 9-р Жавзандамба ба Далай лам нар Жавзандамбын 10-р дүрийг Монголд тодруулах тухай шийдвэр гаргахгүй бол түүний хойд дүрийг 1815 оны Хуулийн эмхэтгэлийн дагуу Төвдөөс тодруулж болзошгүй юм. Энэ нь “гадаад муж”-ийг засах тухай манжийн хууль зүйлийн бичгийг ул үндэстэйгээр судлахыг бидэнд сануулж байна.

<sup>24</sup> Liao Zugui, Chen Qingying, Zhou Wei, On the system of Lot-Drawing from the Golden Urn in the Qing Dynasty, in Social Sciences in China 4(1995), S.18.